



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/᠑᠗.᠐7

Мандалговь

Хязгаарлалт тогтоож, тэг зогсолт
хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 54 дүгээр тогтоол, Аймгийн Онцгой комиссын 2021 оны 16 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирус (COVID-19)-ын халдварын тохиолдол нэмэгдэж байгаа нөхцөл байдалтай холбогдуулан тандалт судалгааны ажлыг зохион байгуулах, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор 2021 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн 15:00 цагаас 06 дугаар сарын 13-ны өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд Сайнцагаан, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Цагаандэлгэр, Өлзийт сумын хэмжээнд иргэн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тэг зогсолт хийж хязгаарласугай.

2. Тэг зогсолт хийсэн сумдуудад бүх төрлийн худалдаа, үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг бүрэн зогсоосугай.

3. Хяналтын цэгүүдийн тоог нэмэгдүүлж, холбогдох байгууллагуудын алба хаагчдыг дайчлан хөдөлгөөнийг хязгаарлаж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Онцгой байдлын газар (М.Адъяабаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Халдвар нэмж тархахаас урьдчилан сэргийлж тандалт судалгааг шуурхай зохион байгуулж, сэжигтэй тохиолдол, ойрын болон дам хавьтлын иргэдээс шинжилгээ авч халдварын голомтын цар хүрээг тогтоож, хариу арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс)-д, голомтын обектод халдваргүйтгэл хийх, арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг тусгай зөвшөөрөл бүхий байгууллагын удирдлагуудад, түүнд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-т тус тус даалгасугай.

5. Шатахуун түгээх станц, эмийн сан, эмнэлгийн байгууллагын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлж, шаардлагатай нөөцийг бүрдүүлж, хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Зайлшгүй шаардлагатай өргөн хэрэглээний хүнс, ус, эм, эмнэлгийн хэрэгслийн хүргэлтийн үйлчилгээг шуурхай зохион байгуулж ажиллахыг Хүнс хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал), "Дундговь-Ус" ОНӨҮГ (О.Бархүү), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

481210563

7. Аймгийн төвд шаардлагатай тусгай үүрэгт ажлаар хөдөлгөөнд оролцох автомашинуудыг аймгийн Онцгой комиссын шуурхай штабын тусгай зөвшөөрлөөр хөдөлгөөнд оролцуулахыг Онцгой байдлын газар (М.Адъяабаатар)-т зөвшөөрсүгэй.

8. Дамжин өнгөрөх тээврийн хэрэгслийг зогсоохгүйгээр өнгөрүүлэхээр зохицуулж хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар)-т үүрэг болгосугай.

9. Буяны ажил, эрүүл мэндийн шалтгаанаар зорчих иргэдийн хүсэлтийг “шуурхай штаб” дээр хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлэн ажиллахыг Шуурхай штабын бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

10. Халдвар бүртгэгдээгүй сумуудад сумын Засаг даргын захирамжаар коронавирус (COVID-19)-ын халдвараас урьдчилан сэргийлэх болон тандалт судалгааны ажлыг зохион байгуулж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг эрчимжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

11. Өвчлөлийн тархалтын байдлыг тогтоох, илрүүлэх хүртэлх хугацаанд халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн гэрээсээ гарахгүй байх, иргэний журамт үүргээ ухамсарлаж мэргэжлийн байгууллага, алба хаагчдаас тавьж буй шаардлагыг бүрэн биелүүлж ажиллахыг нийт иргэдэд уриалсугай.

12. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ